



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 04 дүгэр сарын 26-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-6
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	4-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх/ -ны 04 дүгээр сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Ц.Цэрэнпунцаг.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Тэгшжаргал, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Түр хорооны хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо нар хариулж, тайлбар хийв.

Түр хорооны хуралдааны хаалттай хэлэлцэх асуудлын дараалалд Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн саналыг нэмж оруулж, хэлэлцэхээр тогтов.

Түр хорооны хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Хянан шалгах түр хорооны дотоод асуудал ярих учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

**Ц.Сандаг-Очир:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 0

Бүгд: 3

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

*Нээлттэй хуралдаан 06 минут үргэлжилж, 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 38 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ  
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим 10 цаг  
32 минут.

## ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

### Ц.Сандаг-Очир: .....

Хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий хянан шалгах түр хорооны 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Хуралдаанд түр хорооны гишүүдийн 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирсэн. Хуралдааны ирц 60 хувийн ирцийг хангаж байгаа учраас хуралдааныг нээе.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Доржханд, Сандаг-Очир гэсэн 3 гишүүн хүрэлцэн ирсэн байна аа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгд, Хянан шалгах түр хорооны шинжээч томилох тухай тогтоолын төслийг,

Хоёрт, Нотлох баримт гаргуулах тухай тогтоол гарна,

Гурав, Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын хөлс, шинжээчийн төлбөр, урамшуулалт цалингийн хэмжээг тогтоох, түр хорооны зардал батлах, зарцуулах эрх олгох тухай тогтоолын төсөл гэсэн 3 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж гишүүдэд санал байна уу?

Энх-Амгалан гишүүн асуулт байна.  
Энх-Амгалан гишүүний микрофоныг.

**Б.Энх-Амгалан:** Би бол асуултгүй. Зүгээр 2 санал хэлэх гэсэн юм. Одоо ингээд нөгөө гишүүд тойрогтоо их ажиллаад байгаа учраас ийм тогтоол гаргах дээр одоо зарим нэг ажил явуулах шаардлагатай үед бол Хянан шалгах түр хороог нөгөө хуралдаан даргалагч гарын үсэг зураад юмыг нь баталгаажуулаад яваад байхгүй бол зарим нь байна, байхгүй гээд ганцхан нөгөө Цэрэнпунцаг даргыг хүлээгээд байхаар энэ чинь энэ ажил явахгүй болчих гээд байна л даа.

Тэгэхээр 1 дэх нь энэ дээр нэг санал хураалгаж өгөөч.

Тэгээд хуралдаан зарлаж байгаа тухайн үеийн хүн нь л гарын үсгээ зураад тэр байгууллагууд руугаа бичгээ явуулчихдаг. Ийм байдлаар зохицуулбал энэ бол нэг их тийм дүрэм зөрчөөд байхгүй байх гэж ингэж бодож байна.

Хоёр дахь нь би зүгээр энэ тогтоол дээр нэг санал оруулах гээд байгаа юм. Ашигт малтмал хайх ашиглах зориулалтаар газар, түүний хэвлэлийг тусгай зөвшөөрөл олгох төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэж байгаа юм.

Тусгай зөвшөөрлөөс гадна юм яваад байгаа байхгүй юу. Тэр нь юу вэ гэхээр зэрэг одоо жишээлбэл яг Говь-Алтай аймагт юу гэж байна гэхээр зэрэг зуун хэдэн нөгөө түгээмэл тархацтай ашигт малтмалыг олгоё гээд аймгийнх нь Засаг дарга гарын үсгээ өгчихдөг. Энэнийх нь араас юу болж байна гэсэн чинь нөгөөхөө хайж байна гэдэг нэрээр алт ухаад байгаа байхгүй юу.

Аймгийнхаа төвөөс 200, 300км-ийн алсад уулын дотор түгээмэл тархацтай ашигт малтмал ухааж олоод юм хийнэ гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энийг үзэхийн тулд ийм одоо хууль бус ийм уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэдэг үг өгүүлбэр би нэг найруулгыг нь хийчихье, оруулчихъя, тэгэх үү? Тэгвэл наадах чинь бол яг энэнтэй холбоотой юм гараад ирнэ.

Дараагийнх нь 2 дахь нэг ийм юм байгаа юм. Тэрийг та бүхэн анзаараарай. Хоёр дахь юм нь юу юм бэ гэхээр зэрэг эхлээд очиж тэр газар нь ухчаад ухсаныхаа дараа нөгөө газраа энэ аймгийнхаа нэг одоо байгаль орчны байцаагчийг явуулаад эвдэрсэн газар гэдэг тодорхойлолт гаргуулчихаад, тэрнийхээ араас аймгийн иргэдийн хурал хуралдаж нөгөөхийгөө орон нутгийн хэрэгцээндээ авчхаад. Тэгээд манай орон нутгийн хэрэгцээнд байгаа энэ эвдэрсэн газар дээр тодорхойлолт гаргаж өгнө үү гэж ашигт малтмал руу бичиг явуулж зөвшөөрөл авчхаад тэгээд шууд ухаад эхэлж байгаа юм. Нөгөө лиценз А байхгүй. Х лиценз байхгүй, уулын ажлын төлөвлөгөө байхгүй. Тэгээд нөгөө ашигт малтмалтай холбоотойгоор наадах чинь нөгөө нэг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ байхгүй. Зүгээр автоматаар ухаад эхэлж байгаа байхгүй юу. Ийм юм зөндөө байна.

Тэгэхээр энэ 2-ыг 1 эвтэйхэн энд оруулаадахъя тэгэх үү? Тэгвэл тэгээд л бусад нь асуудал алга.

**Ц.Сандаг-Очир:** Энх-Амгалан гишүүн 2 асуудал хэлж байна. Нэг дэх асуудал нь болох юм байна. Тухайн хуралдааныг даргалагч албажуулаад л яваад гарын үсгээ зураад баталгаажуулаад яваад байж болох юм байна гэж ажлын алба, нэгд.

Хоёр дахь асуулт дээр манай Түр хорооны нарийн бичиг ажлын албаны зөвлөх тайлбар өгчих юм байна. Монголжингоо.

Энэ асчихлаа Монголжингоо тайлбарла.

**Ж.Монголжингоо:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын 25 дугаар тогтоолын нэр нь өөрөө ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гэж нэр нь тэгж гарсан байгаа. Гэхдээ энэ нэрийн хүрээнд буюу энэ шалгалтын ажлын хүрээнд зайлшгүй үзэх ёстой юм бол түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын асуудал орон нутгийн Засаг даргын эрх мэдлээр олгогддог.

Дээрээс нь бичил уурхайн асуудлууд нөгөө ажлын даалгавраа хянан шалгагч, шинжээч нарт хуваарилаад ажил үүргийн хуваарь гаргачихсан байгаа. Тэр хүрээндээ бол гарчихсан. Өнөөдөр дахиад бид нарын нөгөө батлах ёстой нотлох баримтын жагсаалт дотор яг тэрэнтэй холбоотой баримтуудыг аймаг НЗД-аас авна. Дахиад бид нар кадастрын мэдээллийн сангаас ингээд давхиулж харахаар хамаарах бүх байгууллагуудаас нь гаргуулахаар нотлох баримтын жагсаалтдаа орчихсон байгаа. Тийм ажлын даалгаварт бүх юунууд орчихсон байгаа.

**Ц.Сандаг-Очир:** Ойлгомжтой учраас 2 дахь асуудал дээр ингээд тайлбар хэлчихлээ. Энх-Амгалан гишүүний гаргасан энэ эхний саналыг хэлэлцэх асуудлын 4 дүгээрт оруулаад явчихъя.

*Тэгээд санал хураагаад явчихъя тэгэх үү?*

*Тэгээд 4 дэх асуудал хэлэлцэх асуудалд оруулаад томъёоллыг нь бэлдээд өгөөрэй Эрдэнэсамбуу.*

*Ингээд ийм 4 асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлаа баталъя гэсэн гишүүд саналаа өгнө үү.*

*Хэлэлцэх асуудал 100 хувиар дэмжигдлээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.*

*Хэлэлцэх асуудлууд нь Түр хорооны дотоод асуудал учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх саналтай байна.*

*Санал хураах уу? Санал хураалт дэмжье гэдгээр.*

*Хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын санал. Санал дэмжигдсэн учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.*

*10.38 цаг*

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА